

**“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
“АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

2024-12-23

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур	Хугацаа	Гүйцэтгэл
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	Жилдээ	Байгууллагын дотоод сүлжээ, FBook хуудас, сурталчилгааны самбарт зурагт хуудсыг тогтмол оруулж, байгууллагын 1 давхрын мэдээллийн дэлгэцээр АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас зэргийг тухай бүрд нийтэлж оруулсан. 100%
		1.3.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Компанийн ХАБЭА-ийн өдөрлөг, Авлигын эсрэг өдрийг хамтатган нийт Компанийн нийт ажилтнуудад Авлига, ашиг сонирхлын зөрчил, Авлигын гэмт хэрэг, ёс зүйн зөрчил зэрэг сэдвүүдээр ЭБАТ мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж АТГ-ын бэлтгэн гаргасан видео шторкуудыг үзүүлж, хэвлэмэл материалыг тараан нээлттэй өдөрлөг зохион байгуулсан. 100%
		1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах;	-АТГ-ын авлигын мэдээлэл хүлээн авах дугаарыг төрөл бүрийн хэлбэрээр сурталчлан ажилласан байх; -Тайланд 110 дугаарыг сурталчилсан баримт бүрийн нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шүгэл" ажиллагааг дэмжин Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг "НЭГДЬЕ" соён гэгээрүүлэх аяныг улс орон даяар эхлүүлсэн. Төрийн үйлчилгээг түгжрэлгүй болгож авлигын эсрэг НЭГДЬЕ" Шүгэлээ үлээе Товшийг товшоорой видео шторкийг нийтэлж олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн. 100%
		1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос	-Авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн 2-оос доошгүй контент бүтээлгэж олон нийтэд түгээж ажилласан байх;	Жилдээ	АТГ-аас бэлтгэн гаргасан Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэгдсэн контент,видео шторк зэрэг бүтээлийг өөрийн албан ёсны сайт болон дотоод сүлжээнд байршуулан ажилласан. Мөн компанийн нэг давхарт байрлах сургалт,

		доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;		мэдээллийн ТВ-д дээрх сэдвээр тогтмол мэдээлэл хүргэж ажиллаа. 80%
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх;	-Журмыг нийт албан хаагчдад танилцуулах 2 оос доошгүй нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байх;	Жилдээ	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг өдөр тутамдаа мөрдлөгөө болгон ажиллаж байна. Журмыг нийт ажилтан албан хаагчдад танилцуулахаар дотоод сүлжээнд байршуулсан байна. 100%
		2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	-Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаан дахь иргэний нийгмийн оролцоо нэмэгдүүлэхэд чиглэсэн 2-оос доошгүй нөлөөллийн ажил зохион байгуулсан байх;	Жилдээ	ХЭҮК-оос ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд хүний эрх, түүний мөн чанар, хүний эрхийг хамгаалагчийн эрх үүрэг сэдвүүдээр нийт ажилтан албан хаагчдын дунд сургалт мэдээлэл хийлгэж хүний эрх, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар ойлголтыг хүргэн ажилласан. Мөн Дотоодын цэргийн 05 дугаар ангийн 07 дугаар салбартай хамтран авлигын эсрэг гэмт хэргийн талаар сургалт, мэдээллийг зохион байгуулсан. Иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр тогтмол зорилт тавин ажиллаж байна. 80%.
		2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах;	-Төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон өөр олон төрлийн суваг ашиглан сурталчлан таниулах ажлыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх;	Жилдээ	Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудаснаа байршуулсан. Компанийн төсөв, санхүүтэй холбоотой мэдээ мэдээлэл, тайлан мэдээ зэргийг шилэн дансны цахим сайтад тухай бүрд нь хуулийн хугацаанд оруулж ажилласан. Компанийн ЭБАТ-уудын цалин

					урамшууллын талаарх мэдээг ТӨБЗГ-аас ирүүлсэн албан бичгийн хүрээнд хугацаанд нь өөрийн цахим хуудсанд нээлттэй байршуулж ажилласан. 100%
		2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших;	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх. -Ирүүлсэн гомдолд хийсэн дүн шинжилгээний үр дүнд суурилсан эерэг нөлөөллийн арга хэмжээг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх;	Жилдээ	05 сарын 27-ний өдөр Шинээр томилогдсон албан хаагчдад авлигын тухай ойлголт, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг, түүний хор уршиг болон авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад хамруулсан. 80%
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах;	-Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2-оос доошгүй нөлөөллийн ажил зохион байгуулсан байх; -Иргэдэд цахим хэрэглээг таниулж үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх; -Нотломжийг тайланд хавсаргасан байх;	Жилдээ	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг эйбл программд төвлөрүүлж албан бичиг, хүсэлт зэргийг цахим хэлбэрээр гүйцэтгэн шийдвэрлэж байна. Шинээр ажилд орж буй ажилтнуудын баримт бичгийг бүрдлийг И-монголиа аппликейшнээс цахим хэлбэрээр авхуулж цахимд материалуудыг нэгтгэж ажиллаж байна. Ажлын байрны зар түүнд холбогдох материалыг компанийн нууцлал бүхий QRкодоор нэвтрэн мэдээлэл авдаг болсон нь ажилд орох хүсэлтэй иргэний цахим хэрэглээг нэмэгдүүлсэн ажил болсон. 80%
		3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Албан хаагчдын дунд авлигаас ангид байхад чиглэсэн нөлөөллийн 2-оос доошгүй үр дүнтэй ажил зохион байгуулсан байх; -Байгууллагын алба хаагчид авлигын гэмт хэрэгт холбогдоогүй байх;	Жилдээ	Байгууллагын ЭБАТ-д болон ХАСХОМ гаргадаг албан тушаалтнуудын дунд авлигаас ангид байх талаарх сургалт мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна. байгууллагын удирдлагын телеграм группт авлигын эсрэг хууль тогтоомжийг байршуулан ажиллаж байна. байгууллагын албан хаагчид тайлант онд авлига ашиг сонирхол үүссэн нөхцөл байдал үүсээгүй болно.

					100%
		3.3.Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх;	- Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; - Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; - Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх.	Жилдээ	Эрчим хүчний салбарын тэр дундаа эрчим хүч үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тус байгууллагын ажилтан албан хаагчдын онцлогт тохируулан авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг тухайн жил үе шаттайгаар зохион байгуулж ирлээ. Үүнд: ээлж бүрийн 60-н цагийн уулзалт хэлэлцүүлэгт нь компанийн захиргааны мэдээлэлтэй хамтатган авлигын хор уршиг, авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээлэл зөвлөмжийг тогтмол өгч хэвшээд байна. үйлдвэрийн цехүүдийн ээлжийн дарга нарын өрөө болон бусад мэдээллийн самбарт нь АТГ-аас гаргасан гарын авлага сургалт мэдээллийн хуудсыг байршуулж мэдээллийг нь ойр болгох тал дээр анхаарч ажиллаж байна. Компанийн хэмжээнд авлигт өртөж болзошгүй албан тушаал, эрх бүхий албан тушаалтанд дүн шинжилгээ хийж авлигаас ангид байх, өртөх боломж нөхцөлөөс ангид байх талаар тогтмол сануулан, таниулж ажилласан. Уг ажлын үр дүнд авлига ашиг сонирхлын үүдэлтэй аливаа зөрчил үүсээгүй байна. 100%
		3.3.1. Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн ил тод байдлыг хангах, АТГ төслийн нэгжүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;	-Төсөл, хөтөлбөрийн мэдээллүүд ил тод болсон байна; - Томоохон төсөл, хөтөлбөрийн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулсан байх,	Жилдээ	Станцын өргөтгөл шинэчлэлийн ажилтай холбогдуулан Нийслэлийн ЗДТГазар, БНХАУ-ын салбарын инженер техникийн ажилтан нар, Япон улсын холбогдох албан тушаалтан зэрэг хүмүүстэй 4-5 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг хийсэн байна. Дээрх уулзалт хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг тухай бүр нь станцын нээлттэй вэб сайт, групп зэрэгт байршуулан мөн ажилтан, албан хаагчдын уулзалт мэдээллийн үеүдэд тогтмол танилцуулан мэдээллийг ил тод болгож явсан. 100%

		3.3.2. Эрчим хүчний сайдаас баталсан захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах;	-Дүн шинжилгээ хийсэн байх - Зөрчилтэй захиргааны хэм хэмжээний актуудыг хүчингүй болгох, хуулиар эрх олгосон боловч зохих акт гаргаагүй бол боловсруулах, батлах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх;	Жилдээ	Эрчим хүчний сайдаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актуудыг тайлант онд мөрдөн ажиллаж, зөвлөмж үүрэг даалгаварын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм журамд дүн шинжилгээ хийж шинэчлэх шаардлагатай 32 журам, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай 6 журамд өөрчлөлтийг оруулан боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 100%
		3.3.3. Эрчим хүч салбарын алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгахад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;	- Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байх;	Жилдээ	Компанийн ёс зүйн хороо нь 2024 онд нийт 2 удаагын хурал, хэлэлцүүлгийг хийж ёс зүйн зөрчил гаргасан гэх ажилтан албан хаагчдын асуудлыг хэлэлцэн дүгнэлтийг компанийн захиргаанд хүргүүлсэн байна. мөн холбогдох дүүргийн прокурорын газаруудаас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд ёс зүйн хэм хэмжээ, компанийн ёс зүйн дүрмийг танилцуулсан сургалт, мэдээллийн үйл ажиллагааг дотоодын цэргийг 05 дугаар ангийн 07-р салбартай хамтран 2024 оны 12-р сард багтаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 80%
	Хувь үнэлгээ:			92,8%	

...ооо...